

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ,
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН
2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
Зорилт 1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, цалин хөлс, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгож, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр:			
1.	Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан төрийн албан хаагчдын цалин, урамшуулалыг тухай бүр нь шинэчлэн тогтоож олгох	Албан хаагчдын цалин, нэмэгдлийг тухай бүр нь шинэчлэн тогтоож олгогдсон байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс албан хаагчдын цалингийн нэмэгдэлийг ХНУМТ цахим системд нэмж олголоо.
2.	Албан хаагчдад сар бүр унаа хоолны хөнгөлөлтийг олгох	Сар бүр унаа хоолны хөнгөлөлт олгогдсон байна.	- Өдрийн хоолны зардал 599,474,000 төгрөг - Унааны хөнгөлөлт 15,137,000 төгрөг
3.	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад байгууллагаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	Хэмнэлтийн тухай хуулийн дагуу олгогдоогүй.
4.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшууллыг олгох	Хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгогдсон байна.	Монгол Улсын Засгийн газрын 301 дүгээр тогтоолын “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу

			албан хаагчдыг хагас, бүтэн жилээр 208,454,574,65 төгрөгөөр урамшуулж ажиллалаа. II улирал-139,822,873.7 /100%/ IV улирал-68,631,760,95 /75%/
5.	Албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэлийг олгуулах	Албан хаагчдын зэрэг дэв нэмэгдсэн байна.	Төрийн албаны тухай хууль, УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгох журам”-ын дагуу 30 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг олгож ажиллалаа.
Зорилт 2. Албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах, орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр:			
1.	Шинээр ажилд томилогдсон албан хаагчид байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, албан тушаалын тодорхойлолт, дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг шаардлагатай мэдээллийг танилцуулж хэвших	Албан хаагчдыг мэдээллээр хангасан байна.	Мөн Төрийн албаны зөвлөл үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд “Менторшип хөтөлбөр”-ийг байгууллагын “Шинэ ажилтан чиглүүлэх хөтөлбөр”-тэй уялдуулан төлөвлөгөө гарган шинээр томилогдсон 3 албан хаагчийг амжилттай хамруулан төгсгөлөө.
2.	Албан хаагчдын ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр сургалтад хамруулах, дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байна.	Тус газрын Төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний хүрээнд НЗДТГазрын харьяа Хүний хөгжлийн төвтэй хамтран доорх сургалтуудад: Төрийн албаны салбар зөвлөлөөс долоо хоног бүрийн дөрөв дэх өдөр зохион байгуулдаг 7:4:10 сургалтад цахимаар, “Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөр” ажлын байрны, харьяалах дээд байгууллагууд, хамтран ажилладаг байгууллагуудын цаг үеийн

			холбогдолтой сургалтуудад тухай бүр холбогдох албан тушаалтнуудыг хамруулан ажилласан. 2025.02.07 Төрийн албаны зөвлөл, МУЕЗХорооноос зохион байгуулсан 4 цагийн Ёс зүйн дэд хороодын гишүүдэд зориулсан цахим сургалтад байгууллагын Ёс зүйн дэд хорооны 7 гишүүдийг; 2025.03.21 Нийслэлийн хэний нөөцийн хөгжлийн төв, Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан 4 цагийн “Албан хэргийг хос бичгээр хөтлөх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх” сургалтад 5 албан хаагч; 2025.03.25 Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй сургалтад 2 албан хаагчийг; 2025.03.25 Гамшгийн үеийн бэлэн байдлын өмнөх бэлтгэл бэлэн байдлыг хангах болон ямар арга хэмжээ авах талаар 339, 400 дугаар тушаал, 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар сургалтад 42 албан хаагчийг; 2025.04.10 Процессийн дахин инженерчлэл, захиргааны шинэчлэл 4 цагийн сургалтад 6 албан хаагчийг; 2025.04.18 Төрийн албанд хөтлөгддөг нийтлэг баримт бичиг 4 цагийн сургалтад 4 албан хаагчийг 2025.04.22 Төслийн удирдлагын үндэс сэдэвт сургалтад 7 албан хаагчийг; 2025.04.23 Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт 4 цагийн сургалтад 55 албан хаагчийг; 2025.06.09 Нийслэлийн Архивын газартай хамтран “Архив, албан хэрэг хөтлөлт, edoc систем ашиглалт” сэдэвт 4 цагийн сургалтад 31 албан хаагчийг;
--	--	--	---

			2025.09.16 “ТАХ-ын ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт 4 цагийн сургалтад 1 албан хаагчийг; 2025.10.06-18-ны өдрүүдэд Эрүүл мэндийн яамнаас “Аюулгүй, уур амьсгалд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууллага” сэдэвт “Үндэсний сургагч багш” бэлтгэх сургалтад 8 улсын /ахлах/ байцаагчийг; 2025.10.14 Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал 4 цагийн сургалтад 3 албан хаагчийг; 2025.10.03 Нийслэлийн дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, арга зүй сэдэвт 4 цагийн сургалтад 1 албан хаагчийг; 2025.10.17 МУЗГазрын 2025 оны 43 дугаар тотоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам 4 цагийн сургалтад 1 албан хаагчийг 2025.10.22 ERP системийн хэрэглээ 4 цагийн цахим сургалтад 40 албан хаагчийг амжилттай хамруулан ажиллалаа. МУЗГазар, Жендэрийн үндэсний хорооноос жил бүрийн 3 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл уламжлал болгон зохион байгуулагддаг “Харилцан хүндэтгэе” нэг сарын аянд тус газар нь харьяа эрүүл мэндийн байгууллагдын хамт амжилттай оролцлоо. НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам хамтран зохион байгуулсан “Цахим эрүүл мэнд” уулзалт хэлэлцүүлэгт 2025.04.10-11-ны хооронд 1 албан хаагчийг
--	--	--	--

			НИТХурлаас зохион байгуулсан Засаглал, эрх зүйн хэлэлцүүлэгт 2 албан хаагчийг 4 цагийн сургалтат амжилттай оролцуулсан. Сангийн яам, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, СиТиЭс ХХКомпанины нягтлан бодох бүртгэлийн сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн 33 албан хаагчийг 48 цагийн монгол бичгийн анхан шатны сургалтад амжилттай хамруулан ажиллалаа. /Сертификаттай/ Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан “Би тархвар судлаач эмч” Улсын 2дугаар зөвлөлдөх уулзалтад 8 албан хаагчийг хамрууллаа. /Гэрчилгээтэй/ АШУҮИСургуулийн “Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй” 13 ыагц цагийн сургалтад 1 албан хаагчийг хамрууллаа. /Үнэмлэхтэй/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /АЗ/ сургалтад 1 албан хаагчийг хамрууллаа. /Гэрчилгээтэй/ Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагчийг хамрууллаа. /Үнэмлэхтэй/ Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн албан албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагчийг хамрууллаа. /Үнэмлэхтэй/ Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн албан албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3 албан хаагчийг хамрууллаа. /Үнэмлэхтэй/
--	--	--	--

			Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн захиргааны Ахлах түшмэлийн сургалтад 1 албан хаагчийг хамрууллаа. /Үнэмлэхтэй/ Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаад сургалтуудад зохион байгуулагч талын зардлаар хамруулсан. - Япон Улсын NCGM эмнэлгийн дэмжлэгээр 2025 оны 1 сарын 7-9 өдрийн хооронд Японы Нара, Окаяма хотын эмнэлэг хүртлэх тусламж, үйлчилгээний мэдээлэл солилцох системтэй танилцаж туршлага судалсан. /Сертификаттай/ - Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол эмнэлэгтэй хамтран 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан олон улсын эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалж, гадаад сургалтад 2 албан хаагч хамрагдан сертификаттай төгссөн. - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Хятад-Монгол Уламжлалт эмнэлэгт 2025 оны 10 дугаар сарын 12-19-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Эрүүл ирээдүйн төлөө эрүүл мэндийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь" сэдэвт гадаад сургалтад хамрагдсан. /Сертификаттай/ Тайлант онд хичээл үйлдвэрлэл, сургалттай холбоотой 3,989,500 төг зардал гаргасан байна. Үүнээс - А/48 тушаалаар сургалтанд 3.000.000 төгрөг - А/51 тушаалаарх А3 сертификатын сургалт 91.500 төгрөг /Санхүү хөрөнгө орлуулалтын тасгийн мэргэжилтэн Т.Амартүвшин/
--	--	--	---

			- А/58 тушаалаар 398.000 төгрөг /Санхүүгийн “Си ти эс” программын шинэчлэлийн сургалтанд Л.Насанбуян, С.Дээмээ нар хамрагдсан./ - Бичиг хэрэг тараах материал 500000 төгрөг
3.	Гэр хороололд амьдардаг албан хаагчдын судалгааг гаргаж, түрээсийн орон сууц, ипотекийн хөнгөлөлттэй зээлд дугаарын дараалалгүй хамруулах	Албан хаагчид төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлийн байр, орон сууцны зээлэнд хамрагдсан байна.	Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны 6 хувийн ипотекийн зээлэнд 4 албан хаагч хамрагдсан байна.
4.	Албан хаагчдад цалингийн зээлийн хүүгийн хөнгөлөлт эдлүүлэх	Албан хаагчид цалингийн хөнгөлөлттэй нөхцөлийн зээлийн үйлчилгээнд хамрагдсан байна.	Худалдаа хөгжлийн банктai хамтарсан цалингийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийг 1.2 хувиар 32 албан хаагч эдлэсэн байна.
5.	Ажлын байрны тохижилтын үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөл бүрдэж, сэтгэл ханамж дээшилсэн байна.	Хэмнэлтийн тухай хуулийн дагуу олгогдоогүй.
Зорилт 3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үзлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх			
1.	Албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Албан хаагчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.	ЭМХхэлтсийн улсын /ахлах/ байцаагчид 2025 оны 03 дугаар сарын 10-11, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвд эрт илрүүлгийн багц шинжилгээнд 2 ээлжээр хамрагдсан. Эрт илрүүлэгт бүртгүүлсэн нийт 38 хүнээс 25 хүн эхний ээлжинд, 13 хүн хоёрдугаар ээлжинд үзлэг шинжилгээнд орсон. Үүнд 30 эмэгтэй, 8 эрэгтэй ажилтан байна.

		Эрт илрүүлгийн багц шинжилгээнд хамрагдсан нийт ажилчдын шинжилгээний өөрчлөлтийг авч үзвэл: • Элэгний үйл ажиллагааны өөрчлөлттэй - 6 • Элэг өөхлөлттэй - 14 • Элэгний В С вирустай- 1 • Элэгний шохойжилттой-2 • Элэгний хатууралтай-1 • Бөөр шээсний замын халдвартай - 5 • Бөөрний үйл ажиллагааны өөрчлөлттэй- 2 • Цөсний чулуутай- 2 • Цөсний ургацагтай- 2 • Цөсний фермент ихэссэн + цөс өтгөн - 20 • Нойр булчирхайн архаг үрэвсэлтэй- 8 • Цус багадалттай- 2 • Сахартай- / магадлалтай шээсээр сахар гарсан/ - 1 • Бамбайн зангилаатай-6 • Цусан дахь холестерин их- 22 • Ходоод, улаан хоолойн үрэвсэл, сөөргөөтэй- 21 • Ходоод, улаан хоолой, дээд гэдэсний аль нэг шархлаатай- 4 • Уушгины шохойжилт сүүдэртэй- 6 • Хөхний зангилаа-2 • Эмэгтэйчүүдийн үрэвсэл-2 Дээрх өөрчлөлтүүд илэрсэн байна. (давхардсан тоогоор) Дүгнэлт: Нийт шинжилгээнд орсон хүмүүсээс хоол боловсруулах замын өвчлөл зонхилж байгаа бөгөөд нийт шинжилгээнүүдийг ангилан хамгийн их өвчлөл илэрсэн бүлгүүд дээр тоог гаргасан. Нийт ажилчдын дунд Ходоод, улаан хоолойн үрэвсэл сөөргөө, цусан дахь өөх тосны хэмжээ
--	--	--

		ихэссэн, элэг өөхлөлттэй, нойр булчирхайн архаг үрэвсэл, цэс өтгөн хүмүүсийн тоо өндөр байна. Иймээс нийт ажилчид эрүүл зөв хооллож, амьдралын хэв маягийг өөрчлөх шаардлагатай бөгөөд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдаж, архаг хууч өвчтэй хүмүүс эмчийн хяналтанд тогтмол үзүүлж байх шаардлагатай байна. Эрт илрүүлгийн шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан ажилтанд дараагийн шатны нарийн шинжилгээ хийлгэх, эмчийн хяналтанд орох зөвлөгөөнүүдийг өглөө. • Цэсний чулуу /Н, А/ илэрсэн хүмүүс мэс заслын эмчид үзүүлэх. • Бамбайн зангилаа болон цэсний ургацаг, хөхний зангилаа илэрсэн болон уйланхайтай нийт 10 ажилтан 3-6 сар тутам ЭХО-д хянуулж, дааврын шинжилгээ өгөх. • Ходоод, улаан хоолойн сөөргөө болон үрэвсэл шарх илэрсэн нийт ажилтан H.pylori тоолуулж, ходоод гэдэс хоол боловсруулах эмчийн зөвлөгөө авах. • Цус багадалттай болон PLT бага гарсан /Ц/ ажилтан хоол боловсруулахын эмчид үзүүлэх бүдүүн шулуун гэдэс дурандуулах. Эмчилгээ хийлгэх шаардлагатай. • Шээсээр сахар илэрсэн /О/ ажилтан HbA1c буюу сахарын гурван сарын дундаж өгч өндөр гарвал ДШ эмчийн зөвлөгөө авах. • Бөөр шээсний замын үрэвсэлт шохойжилттой 2 хүн байгаа нь дараагын лавлагаа шатлалын шинжилгээг хийлгэж хяналтанд явах.
--	--	---

			• Элэгний хатууралтай, элэгний вирус эерэг гарсан /Б/ ажилтан вирус тоолуулах, хатуурлын зэрэг тодорхойлуулах зайлшгүй шаардлагатай. • Эмэгтэйчүүдийн үрэвсэл илэрсэн хүмүүс зохих эмчилгээг хийлгэж, давтан шинжилгээ өгөх. Санхүүжилт гаргаагүй.
Зорилт 4. Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах, ажиллах идэвх санаачлага, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх			
1.	Албан хаагчдаа өвчлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах арга хэмжээг тогтмолжуулах	Уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулагдсан байна.	Хэмнэлтийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдаагүй.
2.	Ажлын байрны тохижилтын үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх	Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөл бүрдэж, сэтгэл ханамж дээшилсэн байна.	Хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилт шийдэгдээгүй.

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ОЮУН-ЭРДЭНЭ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА У.БАТ-ОЧИР

